



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны 11 дүгээр сарын 18  
№43 (1339)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

658.	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай	Дугаар 34	4023
------	---	-----------	------

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

659.	Журам батлах тухай	Дугаар 93	4028
660.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 98	4040



990.	ᠮᠠᠮᠤ ᠶ᠋ᠢᠨᠵᠢᠨᠢᠨᠢ ᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠢ	ᠪᠠᠭᠠᠨᠠᠨ	᠒᠐᠒᠐
99᠙.	ᠮᠠᠮᠤ ᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠢ <b>Модорд Фоло_ оа Јард оа Гүгт оа Доолгүд</b>	ᠪᠠᠭᠠᠨᠠᠨ	᠒᠐᠙᠘
9᠙᠘.	ᠮᠠᠮᠤ ᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠢ ᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠢ ᠠᠨᠠᠨᠢ ᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠢ ᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠢ ᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠢ <b>Модорд Фоло_ оа Үдд Норгд оа Доолгүд</b>	ᠪᠠᠭᠠᠨᠠᠨ	᠒᠐᠙᠙

ᠠᠨᠠᠨᠢ



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 10 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар  
хот

### Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэг, Төв Банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-нд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

Mongolia Folio\_02 Урдан Ногоо ба Довдого

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭᠣᠯ  
ᠲᠦᠭᠠᠭ 34  
ᠲᠦᠭᠠᠭ 10  
ᠲᠦᠭᠠᠭ 17  
ᠲᠦᠭᠠᠭ 2024

ᠲᠦᠭᠠᠭ 10  
ᠲᠦᠭᠠᠭ 17  
ᠲᠦᠭᠠᠭ 2024

ᠲᠦᠭᠠᠭ 10  
ᠲᠦᠭᠠᠭ 17  
ᠲᠦᠭᠠᠭ 2024

ᠲᠦᠭᠠᠭ 10  
ᠲᠦᠭᠠᠭ 17  
ᠲᠦᠭᠠᠭ 2024

ᠲᠦᠭᠠᠭ 10  
ᠲᠦᠭᠠᠭ 17  
ᠲᠦᠭᠠᠭ 2024

ᠲᠦᠭᠠᠭ 10  
ᠲᠦᠭᠠᠭ 17  
ᠲᠦᠭᠠᠭ 2024

Монгол Улсын Их Хурлын 2024 оны  
34 дүгээр тогтоолын хавсралт

## **ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2025 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

Цар тахлаас эхлэн геополитикийн хурцадмал байдлаар даамжирсан эдийн засгийн хүндрэлийг амжилттай даван туулж, санхүүгийн зах зээл, эдийн засаг сэргээд байна. Энэ сэргэлтийг дунд хугацаанд тогтвортой хадгалахад чиглэсэн мөнгө, санхүүгийн бодлогыг хэрэгжүүлнэ.

### **1.Мөнгөний болон макро зохистой бодлогын хүрээнд:**

1.1.Эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжих, иргэдийн бодит орлогыг хамгаалах зорилгоор инфляцыг дунд хугацаанд 5 хувь (+/-2 нэгж хувийн интервалтай)-ийн орчимд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ. Энэ бодлогыг хэрэгжүүлэхдээ инфляцын зорилтыг 2027 оноос 5 хувь болгон бууруулна.

1.2.Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэн уян хатан тогтох зарчмыг баримтална.

1.3.Макро зохистой бодлогын шийдвэр гаргалтын болон үйл ажиллагааны тогтолцоог нэвтрүүлэн санхүүгийн системийн болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг бууруулахад чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

### **2.Банкны салбарын тогтвортой байдлын хүрээнд:**

2.1.Банкны салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалтын орчныг бүрдүүлнэ.

2.2.Банкнуудын зохистой засаглал, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, хяналт шалгалтын үнэлгээний аргачлалыг олон улсын жишигт үе шаттайгаар нийцүүлнэ.

2.3.Банкны салбарын тогтвортой, ногоон санхүүжилтийн мэдээлэл цуглуулах тогтолцоог бэхжүүлж, уур амьсгалын эрсдэлийн шинжилгээ, стресс тестийн арга зүйг хөгжүүлнэ.

2.4.Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны техник хэрэгжилт, үр дүнтэй байдлын дараагийн харилцан үнэлгээнд бэлтгэж, шууд хэрэгжилтийн үзүүлэлтийн дагуу өөрийгөө үнэлэх болон үндэсний, салбарын эрсдэлийн үнэлгээг эхлүүлнэ.



### **3.Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:**

3.1.Үндэсний төлбөрийн систем болон зээлийн мэдээллийн шинэ үйлчилгээг дэмжиж, цаг үедээ нийцсэн хяналт, зохицуулалтын уялдааг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

3.2.Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтыг төгрөгөөр хийх суурь нөхцөлийг бүрдүүлэн мөнгөний захыг хөгжүүлнэ.

3.3.Олон нийтийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх стратегийг хэрэгжүүлж, Төв Банкны бодлого, үйл ажиллагаа, тэдгээрийн хэрэгжилтийг олон нийтэд нээлттэй, ил тод хүргэж ажиллана.

3.4.Олон нийтийн санхүү, эдийн засгийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлнэ.

3.5.Жижиг, дунд бизнесийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн тогтолцоог олон улсын сайн жишигт нийцүүлэх ажлыг эхлүүлнэ.

---oOo---









## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 03 дугаар  
сарын 06-ны өдөр

Дугаар 93

Улаанбаатар  
хот

### Журам батлах тухай

Төсвийн тухай хуулийн 28<sup>1</sup>.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нар түүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**САНГИЙН САЙД**

**Б.ЖАВХЛАН**

᠕ᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤ ᠵᠠᠰᠦᠭᠢᠨ ᠭᠠᠵᠢ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠨ  
ᠲᠤᠭᠠᠷ ᠑᠓-᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠖-ᠨᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠤᠭᠠᠷ

ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤ ᠬᠣᠲ

ᠵᠢᠷᠢᠨ ᠲᠤᠭᠠᠷ

ᠲᠤᠭᠠᠷ ᠑᠓-᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠖-ᠨᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠤᠭᠠᠷ  
ᠲᠤᠭᠠᠷ ᠑᠓-᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠖-ᠨᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠤᠭᠠᠷ

ᠲᠤᠭᠠᠷ ᠑᠓-᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠖-ᠨᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠤᠭᠠᠷ  
ᠲᠤᠭᠠᠷ ᠑᠓-᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠖-ᠨᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠤᠭᠠᠷ

ᠲᠤᠭᠠᠷ ᠑᠓-᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠖-ᠨᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠤᠭᠠᠷ  
ᠲᠤᠭᠠᠷ ᠑᠓-᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠖-ᠨᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠤᠭᠠᠷ

ᠲᠤᠭᠠᠷ ᠑᠓-᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠖-ᠨᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠤᠭᠠᠷ

ᠲᠤᠭᠠᠷ ᠑᠓-᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠖-ᠨᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠤᠭᠠᠷ

ᠲᠤᠭᠠᠷ ᠑᠓-᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠐᠖-ᠨᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠤᠭᠠᠷ

Mongolia Folio\_03\_2024\_06\_09.docx



Засгийн газрын 2024 оны 03 дугаар  
сарын 06-ны өдрийн 93 дугаар  
тогтоолын хавсралт

## **ТӨСВИЙН ТӨСӨЛ, ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Төсвийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангах зорилгоор жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөл болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахад энэ журмыг баримтална.

1.2.Олон нийтийн хэлэлцүүлэг (цаашид “хэлэлцүүлэг” гэх)-ийг жилийн төсвийн төслийн хувьд жил бүрийн 08 дугаар сарын 15-ны дотор, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн хувьд жил бүрийн 03 дугаар сарын 31-ний дотор, жилийн төсөв болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн хувьд өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн хугацаанд тус тус зохион байгуулна.

1.3.Хэлэлцүүлгийг тов, бүртгэл, зохион байгуулах хэлбэр, дэг зэргийг тодорхой тусгасан заавар бүхий удирдамжийн дагуу зохион байгуулна.

1.4.Жилийн төсвийн төсөл болон төсвийн тодотголын төслийн хэлэлцүүлгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус зохион байгуулна.

1.5.Хэлэлцүүлгийг дараах хэлбэрээр зохион байгуулна:

1.5.1.бичгээр санал авах;

1.5.2.уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;

1.5.3.санал асуулга явуулах;

1.5.4.олон нийтийн цахим сүлжээгээр хэлэлцүүлэг явуулах;

1.5.5. шуурхай утас ажиллуулах;

1.5.6. бусад.

1.6. Хэлэлцүүлэгт иргэд, иргэний нийгмийн байгууллага, Төсвийн тухай хуулийн 10.2-т заасан Зөвлөл, төрийн аудитын байгууллага болон хэлэлцүүлгийн асуудалтай холбоотой салбарын асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын удирдах албан тушаалтан, санхүү, төсвийн асуудал хариуцсан холбогдох албан тушаалтан оролцоно.

1.7. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан мэдээлэлтэй холбоотой асуудлыг олон нийтээр хэлэлцүүлэхгүй.

**Хоёр. Жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын  
төслийн талаарх хэлэлцүүлэг**

2.1. Жилийн төсвийн төслийн талаарх хэлэлцүүлгийг дараах салбарын хүрээнд зохион байгуулна:

2.1.1. эрүүл мэнд;

2.1.2. боловсрол;

2.1.3. шинжлэх ухаан;

2.1.4. хөдөлмөр;

2.1.5. нийгмийн хамгаалал;

2.1.6. соёл;

2.1.7. спорт;

2.1.8. байгаль орчин;

2.1.9. аялал жуулчлал;

2.1.10. хүнс;

2.1.11. хөдөө аж ахуй;

2.1.12. хөнгөн үйлдвэр;

2.1.13. хүнд үйлдвэр;



- 2.1.14.уул уурхай;
- 2.1.15.барилга;
- 2.1.16.зам, тээвэр;
- 2.1.17.эрчим хүч;
- 2.1.18.хууль зүй;
- 2.1.19.аюулгүй байдал;
- 2.1.20.цахим хөгжил;
- 2.1.21.харилцаа холбоо;
- 2.1.22.гадаад харилцаа;
- 2.1.23.бусад.

2.2.Харилцан уялдаа холбоо бүхий салбарын хэлэлцүүлгийг нэгтгэн зохион байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд хэлэлцүүлгийг салбар тус бүрээр явуулна.

2.3.Төсвийн тодотголын төслийн талаарх хэлэлцүүлгийг тухайн тодотголын хүрээнд шийдвэрлэхээр тодорхойлсон асуудлын хүрээнд зохион байгуулна.

2.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хэлэлцүүлгийг салбарын асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчтай хамтран энэ журмын 1.5.1-1.5.6-д заасан хэлбэрийн аль тохирохоор зохион байгуулна.

2.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэлэлцүүлгийн удирдамжийг боловсруулж, салбарын асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчид албан бичгээр хүргүүлэх бөгөөд гурваас доошгүй мэдээллийн сувгаар олон нийтэд мэдээлнэ.

2.6.Хэлэлцүүлэх асуудлын хүрээ нь Төсвийн тухай хуулийн 14.2.1-д заасны дагуу тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан байна.

2.7.Төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем”-ээр жил бүрийн 04 дүгээр сарын 01-ний дотор олон нийтээс санал авах бөгөөд саналыг “Улсын төсвийн



хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал"-ын дагуу эрэмбэлэн, төсвийн төсөлд хэрхэн тусгасныг хэлэлцүүлгийн үед танилцуулна.

2.8.Хэлэлцүүлэг зохион байгуулахад шаардагдах зардлыг салбарын тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлнэ.

2.9.Хэлэлцүүлгээс гарсан дараах шаардлага хангасан саналыг тухайн жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөлд эрэмбэлэн тусгана:

2.9.1.эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдол бүхий, зардал бууруулах санал байх;

2.9.2.зардал нэмэгдүүлэх санал нь зардал бууруулах саналтай хамт гарсан байх;

2.9.3.улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй нийцтэй байх;

2.9.4.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байх.

2.10.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэлэлцүүлгээс гарсан саналыг жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөлд хэрхэн тусгасан талаар олон нийтэд зохистой хэлбэрээр мэдээлнэ.

**Гурав.Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл,  
дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт,  
өөрчлөлт оруулах төслийн талаарх хэлэлцүүлэг**

3.1.Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн талаарх хэлэлцүүлгийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.1-д заасан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтийн хүрээнд зохион байгуулна.

3.2.Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаарх хэлэлцүүлгийг тухайн нэмэлт, өөрчлөлт хийгдэх үзүүлэлтийн хүрээнд зохион байгуулна.

3.3.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хэлэлцүүлгийг холбогдох байгууллагатай хамтран энэ журмын 1.5.1-1.5.6-д заасан хэлбэрийн аль тохирохоор зохион байгуулна.



3.4.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэлэлцүүлгийн удирдамжийг боловсруулж, холбогдох төрийн байгууллагад албан бичгээр хүргүүлэх бөгөөд гурваас доошгүй мэдээллийн сувгаар олон нийтэд мэдээлнэ.

3.5.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэлэлцүүлгээс гарсан саналыг дүгнэж, хөгжлийн урт, дунд хугацааны тэргүүлэх чиглэл болон бодлогын баримт бичигт нийцсэн, үндэслэл бүхий тооцоо судалгаатай саналыг төсвийн нөөц боломжтой уялдуулан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд тусгана.

3.6.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд олон нийтийн саналыг хэрхэн тусгасан тайлбарыг хэлэлцүүлэг болсноос хойш 7 хоногийн дотор нийтэд мэдээлнэ.

---o0o---

















## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 03 дугаар  
сарын 06-ны өдөр

Дугаар 98

Улаанбаатар  
хот

### Журам шинэчлэн батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 57.2.3, Шүүх шинжилгээний тухай хуулийн 72.8.2, 72.9-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгоход шаардагдах хөрөнгийг тухайн жилийн батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаярт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” (Шүүх шинжилгээний ажилтны онцгойн нэмэгдэл) Засгийн газрын 2012 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 85 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД**

**Х.БУЛГАНТУЯА**

## Mongolian Folio - on Gede on Dorelge

МОНГОЛЫН ХАМГААГАХ  
УЛСЫН ХАМГААГАХ

ХЭМЖЭЭН 70

2024 оны 43 дугаар үзэмж

### МОНГОЛЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ

МОНГОЛЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ  
УЛСЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ

«МОНГОЛЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ  
УЛСЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ»

МОНГОЛЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ  
УЛСЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ

МОНГОЛЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ  
УЛСЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ УЛСЫН ХАМГААГАХ

МОНГОЛ - ХАМГААГАХ

МОНГОЛЫН ХАМГААГАХ

МОНГОЛЫН ХАМГААГАХ

МОНГОЛЫН ХАМГААГАХ



Засгийн газрын 2024 оны 03 дугаар  
сарын 06-ны өдрийн 98 дугаар  
тогтоолын хавсралт

**ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИД  
АЛБАН АЖЛЫН ОНЦГОЙ НӨХЦӨЛИЙН НЭМЭГДЭЛ  
ОЛГОХ ЖУРАМ**

1.Шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчид төрийн тусгай алба хааж байх хугацаанд нь албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.

2.Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг алба хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингаас доор дурдсан хувиар бодож сар бүр олгоно:

№	Албан тушаалын нэр	Нэмэгдлийн хэмжээ (үндсэн цалингийн хувиар)
2.1.	Лабораторийн эрхлэгч, мэргэшсэн шинжээч, чиглэлийн ахлах шинжээч, ахлах шинжээч, шинжээч, мэргэшсэн шинжээч эмч, ахлах шинжээч эмч, шинжээч эмч, ахлах сэтгэцийн эмч, сэтгэцийн эмч, сэтгэл зүйч, таниулах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, бага эмч, лаборант, рентген техникч, туслах ажилтан, сан хариуцсан мэргэжилтэн болон ажилтан, санч, шуурхай албаны жолооч	25
2.2.	Захиргаа, санхүү, аж ахуй, аюулгүй байдал, хяналт шалгалт, эрдэм шинжилгээ, сургалт, бүртгэлийн алба хаагч болон бусад алба хаагч, ажилтан	20

3.Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

4.Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг гадаад, дотоодын ижил төрлийн байгууллага, олон улсын болон бусад байгууллагад туршлага судлах, мэргэжлийн сургалтад хамрагдах, хурал, зөвлөгөөнд оролцохоос бусад чөлөөтэй, өвчтэй байх хугацаанд олгохгүй.

---о0о---



Хэргийн гэрээний 30-ыг хүлээн  
гэрээний 60-ыг хүлээн гэрээний  
30-ыг хүлээн гэрээний

Хэргийн гэрээний 30-ыг хүлээн  
гэрээний 60-ыг хүлээн гэрээний  
30-ыг хүлээн гэрээний

Хэргийн гэрээний 30-ыг хүлээн  
гэрээний 60-ыг хүлээн гэрээний  
30-ыг хүлээн гэрээний

Хэргийн гэрээний (Хэргийн гэрээний)	Хэргийн гэрээний Хэргийн гэрээний
30	Хэргийн гэрээний Хэргийн гэрээний
60	Хэргийн гэрээний Хэргийн гэрээний

Хэргийн гэрээний 30-ыг хүлээн  
гэрээний 60-ыг хүлээн гэрээний  
30-ыг хүлээн гэрээний





**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 1.5

**Индекс: 200003**